

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 он 3 сар 4 өдөр

№ 16/005

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.2-т заасны дагуу “Э-транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. “Э-транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дугаар сарын 15-ний 15:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт оросноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах,
 - б) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт,
 - в) Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан,
 - д) Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах,
 - е) Компанийн аудитын хорооны тайлан,
 - ж) ТУЗ-ийн гишүүдийг сонгох,
 - г) ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв,
 - h) Ногдол ашиг тараах эсэх шийдвэр танилцуулах,
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2016 оны 03 дугаар сарын 9-ны өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд компанийн Улаанбаатар хот дахь байранд болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд тус тус танилцаж болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Энхболд, тооллогын комиссын даргаар Э.Ариунтуяа, гишүүдээр С.Отгонбаяр, "БиДиСЕК" ХК-ийн мэргэжилтэн Ц.Цог нарыг тус тус томилсугай.



Handwritten signature in blue ink.

Ч.Энхболд